



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 127

Жаргалтхаан сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаврын хуурайшилт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах зорилгоор түймэр унтраах багаж хэрэгсэл авахад зориулж 1 613 500 (Нэг сая зургаан зуун арван гурван мянга таван зуу) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 1 613 500 (Нэг сая зургаан зуун арван гурван мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын эрсдлийн сангийн нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Т.Энхсайхан нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.ГАНБАТ